НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 10 өдөр Дугаар А/207 Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 14.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 115 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2023 онд "Замын хөдөлгөөний удирдлага зохион байгуулалтын ухаалаг систем" нэвтрүүлэх ажлын хүрээнд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хавсралтаар баталж, уг төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар (Г.Энхтайван)-т шилжүүлэн, холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг үүрэг болгосугай.

2.Захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай 3,000.0 (гурван тэрбум) төгрөгийг "Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2022-2023 он дамжин санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"-ын "Авто замын түгжрэлийг бууруулах төсөл, арга хэмжээний жагсаалт"-ын 9 дахь заалтад заасан "Замын хөдөлгөөний удирдлага зохион байгуулалтын ухаалаг систем"-ийн хөрөнгөөс гүйцэтгэлээр нь холбогдох хууль, журмын дагуу хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Б.Бямбасүрэн)-т, нээсэн эрхийг үндэслэн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Наранбаатар) -т, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар (О.Чинзориг)-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (Ч.Сайханбаяр)-т тус тус даалгасугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан "Эрх шилжүүлэх тухай" Нийслэлийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/503 дугаар захирамжийн хавсралтын 1 дэх заалт, "Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай" Нийслэлийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/1270 дугаар захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

1110200944

4.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэнд даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ Д.СУМЪЯАБАЗАР

Нийслэлийн Засаг даргын 2023 оны
03 дугаар сарын 10-ны өдрийн
А/604 дугаар захирамжийн
хавсралт

НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2023 ОНД "ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН УХААЛАГ СИСТЕМ" АЖЛЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

(сая төг)

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2023 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
1	Авто тээврийн хэрэгслийн цахим гэрчилгээ (RFID tag)-г суурилуулах	2022	2023	3,000.0	3,000.0
ДҮН				3,000.0	3,000.0